



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2013 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/280

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах тухай" 2013 оны 78 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Наранбаатар овогтой Билгүүдэйг АНУ-ын Лос Анжелос дахь Калифорний их сургуулийн бакалаврын сургалтад байгалийн шинжлэх ухааны чиглэлээр 4 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР